# ГАЗРЫН БИРЖИЙН ХЭЛТСИЙН ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ Ш.МАНДАХЗУЛЫН 2024 ОНЫ АЖЛЫН ГҮЙЦЭТГЭЛ, ҮР ДҮН, МЭРГЭШЛИЙН ТҮВШИНГ ҮНЭЛЭХ ҮНЭЛГЭЭНИЙ ХУУДАС

Байгууллагын нэр: Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн ерөнхий газар

Нэгжийн нэр: Газрын биржийн хэлтэс

**1. Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт**

| Д/д | Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээ | Гүйцэтгэлийн түвшин | Нийт (70 оноо) |
|---|---|---|---|
| 1 | 2 | 3 | 4 |
| 1. | Нэгжийн гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт | 57.3 | 57.3 |

**2. Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний биелэлт**

| Д/д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Арга хэмжээний биелэлтийн хувь | Төсвийн шууд захирагчийн өгсөн үнэлгээ (15 хүртэл оноогоор) |
|---|---|---|---|
| 1. | Арга хэмжээ 1. | 15 | 15 |
| 2. | Арга хэмжээ 2. | 15 | 15 |
| **Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний дундаж оноо** | | | 15 |

**3. Хандлага, ёс зүй, ур чадварын үнэлгээ**

| Д/д | Үзүүлэлт | Төсвийн шууд захирагчийн өгсөн үнэлгээ (15 хүртэл оноогоор) |
|---|---|---|
| 1. | Хандлага, ёс зүй | 15 |
| 2. | Удирдан зохион байгуулах | 15 |
| 3. | Асуудал шийдвэрлэх | 15 |
| 4. | Манлайлах | 15 |
| 5. | Багаар ажиллах | 15 |
| 6. | Харилцаа | 15 |
| Ур чадварын үзүүлэлт (ажлын онцлогоос хамаарсан) | | |
| 7. | Мэргэжлийн ур чадвар 1. | 15 |
| 8. | Мэргэжлийн ур чадвар 2. | 15 |
| 9. | Мэргэжлийн ур чадвар 3. | 15 |
| **Хандлага, ёс зүй, ур чадварын дундаж оноо** | | 15 |

**4. Гүйцэтгэлийн үнэлгээ**

| Д/д | Үнэлгээний үзүүлэлт | Үзүүлэлт тус бүрийн оноо |
|---|---|---|
| 1. | Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт *(Нэгжийн гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт) 70 хүртэлх оноо* | 57.3 |
| 2. | Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний биелэлт *(Төсвийн шууд захирагчийн үнэлгээ ) 15 хүртэлх оноо* | 15 |
| 3. | Хандлага, ёс зүй, ур чадварын үнэлгээ *(Төсвийн шууд захирагчийн үнэлгээ ) 15 хүртэлх оноо* | 15 |
| 4. | Үнэлгээний оноонд орсон өөрчлөлт | |

| | | |
|---|---|---|
| | *(Аргачлалын 6 дугаар хэсэгт заасан холбогдох заалтыг бичих)* | |
| **Нийт оноо =** ( Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний оноо + Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний оноо + Хандлага, ёс зүй, ур чадварын оноо ) - Аргачлалын 6 дугаар хэсгийн холбогдох заалтын дагуу хассан оноо | | 87.3 |

***Үнэлгээ өгсөн:***

Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн ерөнхий газрын дарга

***Төсвийн шууд захирагч***

(А.Энхманлай)

*........ оны ...... дугаар сарын ..... -ны өдөр*

***Үнэлгээтэй танилцаж, зөвшөөрсөн:***

Газрын биржийн хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч

***Нэгжийн дарга:***

............................................ (Ш.Мандахзул)

*........ оны ...... дугаар сарын ..... -ны өдөр*

ГАЗАР ЗОХИОН БАЙГУУЛАЛТ, ГЕОДЕЗИ, ЗУРАГ ЗҮЙН ГАЗРЫН ГАЗРЫН БИРЖИЙН ХЭЛТСИЙН 2024 ОНЫ ГҮЙЦЭТГЭЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ЖИЛИЙН ЭЦСИЙН ТАЙЛАН

## НЭГ. БОДЛОГЫН БАРИМТ БИЧИГТ ТУСГАГДСАН ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭ

| Д/д | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Төсөв | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Зорилтот түвшин | Хүрсэн түвшин буюу хэрэгжилт /хүрээгүй бол тайлбар/ | Гүйцэтгэл -ийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| **Стратеги төлөвлөгөөний зорилго 1.10.<br>Цахим үйл ажиллагаатай газрын биржийг газрын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын эрхлэх асуудлын хүрээнд байгуулж, газар, үл хөдлөх хөрөнгийн нэгдсэн системийг бий болгоно.** | | | | | | | |
| **1.10.1** | **Цахим үйл ажиллагаатай газрын бирж байгуулах** | **БХБ-ын сайдын багц** | **ТЭЗҮ - 1** | **2018 онд Газрын биржийн цахим системийг хэрэглээнд нэвтрүүлсэн.** | **Цахим үйл ажиллагаатай Газрын биржийг газрын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын эрхлэх асуудлын хүрээнд байгуулах ажлын ТЭЗҮ боловсруулах ажлыг зохион байгуулсан байна.** | | |
| 1.10.1.1 | Газрын биржийн цахим системээр газар өмчлөх, эзэмших, ашиглах эрхийн дуудлага худалдаа, эзэмших, ашиглах эрхийн төсөл сонгон шалгаруулалт зохион байгуулах | Үйл ажиллагаа | Тухайн жилийн төлөвлөгөөнд тусгагдсан нэгж талбарын тоо | Газрын биржийн цахим системээр зохион байгуулах боломж бүрдсэн. | Тухайн жилийн төлөвлөгөөнд дуудлага худалдаа, төсөл сонгон шалгаруулалтаар олгохоор төлөвлөсөн газарт зохион байгуулсан байна. | Газрын биржийн цахим систем /www.mle.mn/-ээр газар өмчлөх, эзэмших, ашиглах эрхийн дуудлага худалдаа, төсөл сонгон шалгаруулалт зохион байгуулах ажлын хүрээнд дараах ажлыг хийж гүйцэтгээд байна. Үүнд:<br>- 2024 оны жилийн эцсийн байдлаар нийт 1,965 газрын дуудлага худалдаа зохион байгуулсан. Нийт зохион байгуулагдсан дуудлага худалдааны 1,630 нь цахим хэлбэрээр, 335 нь танхимаар зохион байгуулагдсан. Дуудлага худалдаанд нийт 4728 иргэн, хуулийн этгээд оролцож, 12.9 тэрбум төгрөгийн орлогыг Улсын төсөвт төвлөрүүлээд байна.<br>- 2024 оны жилийн эцсийн байдлаар нийт 1,179 газрын | 100 |



33

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | газар эзэмших, ашиглах эрхийн төсөл сонгон шалгаруулалт зохион байгуулсан. Үүнээс 1,160 нь Монгол улсын Засгийн газраас хэрэгжүүлж буй Хөдөөгийн сэргэлтийн хүрээнд өрнүүлж байгаа малчдын "Шинэ хоршоо хөдөлгөөн"-ийг хэрэгжүүлэхэд чиглэгдсэн газар эзэмших төсөл сонгон шалгаруулалт зэзлж байх бөгөөд 261 газрыг малчдын хоршоонд эзэмшүүлээд байна.<br>Мөн дараах чиглэлийг 21 аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар, Нийслэлийн Газар зохион байгуулалтын албанд хүргүүлж ажилласан. Үүнд:<br>- Газрын тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.2.4-т заасны дагуу тухайн жилд эзэмшүүлэх, ашиглуулах газрын байршил, хэмжээ, зориулалтын жагсаалтыг эцэслэн батлах хүртэл дуудлага худалдаа, төсөл сонгон шалгаруулалтыг байгуулахгүй байх чиглэлийг 2024 оны 02 дугаар сарын 21-ний өдрийн 1/454 дугаар албан бичгээр;<br>- Газрын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.1.2 дахь заалт болон 33.5 дахь хэсэгт өөрчлөлт орж, мал аж ахуйн үйлдвэрлэл эрхлэх зориулалтаар малчдын хоршоонд нэг удаа 5 га хүртэлх газрыг төсөл сонгон шалгаруулалтын зарчмаар эзэмшүүлэх, төсөл сонгон шалгаруулалтыг зохион байгуулах, зарыг Газрын биржийн цахим системд бүртгэж байх чиглэлийг 2024 оны 06 дугаар сарын 04-ний өдрийн 1/1421 дугаар албан бичгээр: | |
| 1.10.1.2 | "Газрын биржийн удирдах зөвлөлийн | Үйл ажиллагаа | 1 хурал | БХБ-ын сайдын 2018 оны 106 | Газрын биржийн удирдах зөвлөлийн бүрэлдэхүүнийг | Монгол Улсын Засгийн газрын 2023 оны 454 дүгээр тогтоолоор Газар | 90 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | хурал"-ыг зохион байгуулах | | | дугаар тушаалаар ажлын хэсэг байгуулагдсан. | шинэчлэн байгуулж, "Газрын биржийн удирдах зөвлөлийн хурал"-ыг зохион байгуулсан байна. | зохион байгуулалт, геодези, зураг зүйн ерөнхий газар нь Монгол улсын Ерөнхий сайдын харьяанд шилжиж, өөрчлөлт орсонтой холбогдуулан "Газрын биржийн удирдах зөвлөлийн бүрэлдэхүүн, түүний ажиллах журам"-ыг шинэчлэх шаардлага гарсан тул Газрын биржийн үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх, салбар хоорондын уялдаа, хяналтын тогтолцоог хангуулах үүрэг бүхий удирдах зөвлөлийн бүрэлдэхүүнийг шинэчлэн, ажиллах журмын төслийг боловсруулан Засгийн газарт хүргүүлсэн.<br>Тус журмын дагуу бүрэлдэхүүн шинэчлэгдсэний дараа тус Газрын биржийн удирдах зөвлөлийн хурлыг зохион байгуулахаар төлөвлөж байгаа бөгөөд хурлын бэлтгэл ажлыг хангаад байна. | |
| **Стратеги төлөвлөгөөний зорилго 1.22.<br>Хүн амын нутагшилт, суурьшлын зохистой тогтолцоонд тулгуурлан хот байгуулалт, газрын харилцааны эрх зүйн орчныг боловсронгуй болгоно.** | | | | | | | |
| **1.22.2** | **Захиргааны чиглэлээр эрх зүйн актуудын хэрэгжилтэд дүн шинжилгээ хийх, боловсронгуй болгох** | **Үйл ажиллагаа** | **Жил бүр 5-аас доошгүй эрх зүйн акт** | **Жил бүр 10 орчим эрх зүйн акт боловсруулж байна.** | **Нийт эрх зүйн актын 10 орчим хувийг шинэчилсэн байна.** | | |
| 1.22.2.15 | "Газар өмчлүүлэх, эзэмшүүлэх, ашиглуулах дуудлага худалдаа явуулах журам"-ыг шинэчлэн боловсруулах ажлыг зохион байгуулж, Засгийн газрын хуралдаанд танилцуулж, батлуулах ажлыг зохион байгуулах | Үйл ажиллагаа | Журмын төсөл, Засгийн газрын тогтоолын төсөл | Засгийн газрын 2016 оны 10 дугаар тогтоолоор батлагдсан. | **Эхний хагас жилд:**<br>Газар өмчлөх, эзэмших, ашиглах дуудлага худалдаа зохион байгуулах журмыг боловсруулж, холбогдох байгууллага, албан тушаалтнаас санал авч, журам болон Засгийн газрын тогтоолын төслийг ЗГХЭГ-т хүргүүлсэн байна. | Засгийн газрын 2016 оны 10 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар батлагдсан "Газар өмчлүүлэх, эзэмшүүлэх, ашиглуулах дуудлага худалдаа явуулах журам"-д нэмэлт өөрчлөлт оруулахаар Засгийн газрын тогтоолын төслийг боловсруулсан бөгөөд журмын нэмэлт, өөрчлөлтөөр дараах асуудлуудыг шийдвэрлэхээр тусгасан. Үүнд:<br>1. Цахим хэлбэрээр зохион байгуулагдаж буй дуудлага худалдааны оролцогчийн эрх үүрэг;<br>2. Дуудлага худалдааны ялагч гэрээ байгуулаагүй, дуудлага | 90 |



35

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | худалдааны үнийг бүрэн төлөөгүй тохиолдолд цахим системд хандах эрхийг хязгаарлах болон бусад хуульд заасан арга хэмжээг авч зөрчлөөс үүдэлтэй хохирлыг төлүүлэх;<br>3. Дуудлага худалдаагаар олгох газар дээр Зөвшөөрлийн тухай хуульд заасны дагуу тусгай зөвшөөрөл бүхий аж ахуйн нэгж, байгууллагыг оролцуулах;<br>4. Дуудлага худалдааны ялагчтай заасан хугацаанд гэрээ байгуулаагүй, дуудлага худалдааны үнийг бүрэн төлөөгүй тохиолдолд дараагийн өндөр үнийн санал өгсөн оролцогчийг ялагчаар тодруулах;<br>5. Дуудлага худалдааны орлогын 30 хувь болон хүчингүй болсон дуудлага худалдааны дэнчинг улсын төсөвт төвлөрүүлж, холбогдох арга хэмжээнд зарцуулах;<br>6. Дуудлага худалдааны дэнчингийн хэмжээг тухайн газрын дуудлага худалдааны анхны үнээс нь хамааруулах;<br>7. Дуудлага худалдааны ялагчтай байгуулах гэрээг цахимаар байгуулах.<br>Тус журмын төслийг 2024 оны 10 дугаар сарын 03-ны өдөр аймаг, нийслэл, дүүргийн асуудал хариуцсан мэргэжилтнүүдэд танилцуулж, санал авсан бөгөөд холбогдох хэлтсийн дарга нараар хянуулж, санал авч тус газрын даргын зөвлөлийн 2024 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн 24 дүгээр хурлаар хэлэлцүүлсэн. | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1.22.2.16 | “Газар эзэмшүүлэх, ашиглуулах төсөл сонгон шалгаруулах журам”-ыг шинэчлэн боловсруулах ажлыг зохион байгуулж, Засгийн газрын хуралдаанд танилцуулж, батлуулах ажлыг зохион байгуулах | Үйл ажиллагаа | Журмын төсөл, Засгийн газрын тогтоолын төсөл | Засгийн газрын 2016 оны 10 дугаар тогтоолоор батлагдсан. | **Эхний хагас жилд:** Газар эзэмших, ашиглах төсөл сонгон шалгаруулалт явуулах журмыг боловсруулж, холбогдох байгууллага, албан тушаалтнаас санал авч, журам болон Засгийн газрын тогтоолын төслийг ЗГХЭГ-т хүргүүлсэн байна. | Уламжлалт мал аж ахуйд тулгамдаж байгаа уур амьсгалын өөрчлөлтөөс шалтгаалсан сөрөг нөлөөллийг бууруулах тухай хууль батлагдсанаар Газрын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.1.2 дахь заалтад өөрчлөлт орж, мал аж ахуйн үйлдвэрлэл эрхлэх зориулалтаар малчдын хоршоонд нэг удаа 5 га хүртэлх газрыг төсөл сонгон шалгаруулалтын зарчмаар эзэмшүүлэх болсонтой холбогдуулан холбогдох судалгаа, шинжилгээг хийж “Газар эзэмшүүлэх, ашиглуулах төсөл сонгон шалгаруулах журамд нэмэлт өөрчлөлт оруулах тухай” тогтоолын төслийг боловсруулж тус газрын Хуулийн хэлтэст хүргүүлж, “Газар эзэмшүүлэх, ашиглуулах төсөл сонгон шалгаруулах журам”-д нэмэлт, өөрчлөлт оруулах ажлыг зохион байгуулсан.<br>Тогтоолын хавсралтад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай Засгийн газрын тогтоолын төслийг боловсруулж, 2024 оны 04 дүгээр сарын 25-ны өдөр Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хүргүүлсэн бөгөөд Засгийн газрын 2024 оны 05 дугаар сарын 01-ний өдрийн хуралдаанаар хэлэлцэж, Засгийн газрын 2024 оны 187 дугаар тогтоолоор “Газар эзэмшүүлэх, ашиглуулах төсөл сонгон шалгаруулах журам”-д нэмэлт, өөрчлөлт оруулсан болно. | 100 |
| 1.22.2.18 | “Газар эзэмших, ашиглах эрхийн гэрчилгээний дуудлага худалдааны анхны үнийг тодорхойлох аргачлал”-ыг шинэчлэн боловсруулах | Үйл ажиллагаа | 1 аргачлал | БХБ-ын сайдын 208 дугаар тушаалаар батлагдсан. | **Эхний хагас жилд:** Аргачлалын төслийг шинэчлэн боловсруулж, холбогдох байгууллагаас санал авсан байна.<br>**Жилийн эцэст:** Аргачлалын төслийг холбогдох хурлаар | Монгол Улсын Их Хурлаас 2023 оны 11 дүгээр сарын 10-ны өдөр Газрын тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулж газрын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага Газар эзэмших, ашиглах эрхийн гэрчилгээний дуудлага худалдааны анхны үнийг тодорхойлох аргачлалыг батлахаар зохицуулсантай | 90 |



37

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | хэлэлцүүлж, батлуулсан байна. | холбоотойгоор Барилга, хот байгуулалтын сайдын 2018 оны 208 дугаар тушаалаар батлагдсан "Газар эзэмших, ашиглах эрхийн дуудлага худалдааны анхны үнэ тодорхойлох аргачлал"-ыг шинэчлэн боловсруулсан.<br>Тус аргачлалыг шинэчлэн боловсруулахдаа 21 аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар, Нийслэлийн Газар зохион байгуулалтын албанд мэдээлэл ирүүлэх тухай 2024 оны 04 сарын 22-ны өдрийн 1/1045 дугаар албан бичгийг хүргүүлж, дуудлага худалдаагаар олгосон газар, дуудлага худалдааны анхны үнэ төлүүлсэн эсэх, үнэлгээний бүс тогтоосон ИТХ-ын тогтоол, бүсийн зураг зэрэг мэдээллийг авч холбогдох судалгааг хийж гүйцэтгэсэн. Мөн 2024 оны 10 дугаар сарын 03-ны өдөр аймаг, нийслэл, дүүргийн асуудал хариуцсан мэргэжилтнүүдэд сургалт зохион байгуулж санал авч аргачлалын төслийн боловсруулсан. Тус газрын холбогдох хэлтсийн дарга нараар хянуулж, санал авч газрын даргын зөвлөлийн 2024 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн 24 дүгээр хурлаар хэлэлцүүлсэн. | |
| 1.22.2.23 | "Нийтийн сервитут тогтооход нөхөх олговрын хэмжээг тооцох, нөхөх олговрыг тогтоох, нөхөх олговрыг дүйцүүлэн тооцох журам"-ын төсөл боловсруулах | Үйл ажиллагаа | 1 журам | - | **Эхний хагас жилд:**<br>Нийтийн сервитут тогтооход нөхөх олговрын хэмжээг тооцох, нөхөх олговрыг тогтоох, нөхөх олговрыг дүйцүүлэн тооцох журмын төслийг боловсруулж, холбогдох хурлаар хэлэлцүүлж, батлуулсан байна. | "Нийтийн сервитут тогтоосон газарт нөхөн олговрын хэмжээг тооцох, нөхөн олговрыг тогтоох, нөхөн олговрыг дүйцүүлэн тооцож олгох журам"-ын төсийг шинээр боловсруулан Захиргааны ерөнхий хууль болон бусад холбогдох хууль, журамд нийцүүлэн боловсруулж, Хууль зүй дотоод хэргийн сайдын 2018 оны А/147 дугаар тушаалаар баталсан нөлөөллийн шинжилгээ хийх аргачлалын дагуу нөлөөллийн шинжилгээ хийж 2024 оны 03 дугаар | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | сарын 13-ны өдрийн ДДЗХ-р хэлэлцүүлэн дэмжсэн бөгөөд Газрын даргын 2024 оны А/180 дугаар тушаалаар батлуулж, 2024 оны 05 дугаар сарын 30-ны өдрийн 1/1375 дугаар албан бичгээр Хууль зүй, дотоод хэргийн яамны захиргааны хэм хэмжээний актад бүргүүлэх хүсэлтээ хүргүүлж тус яамны захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн сангийн 6848 дугаарт бүртгэсэн. | |
| 1.22.2.33 | Шинээр батлагдсан хууль, дүрэм, журам, стандартыг албан хаагчдад мэдээлэх, олон нийтэд сурталчлах, мэдээлэл өгөх ажлыг зохион байгуулах | Үйл ажиллагаа | Сургалтын тоо<br><br>Хамрагдсан иргэн, хуулийн этгээдийн тоо | 5 удаагийн сургалт, мэдээллийн цагийг зохион байгуулсан. | Газрын харилцааны салбарт шинээр болон шинэчлэн батлагдсан эрх зүйн баримт бичгийг салбарын мэргэжилтнүүд, аж ахуйн нэгжүүдэд мэдээлэх, танилцуулах сургалтыг зохион байгуулсан байна. | Шинээр батлагдсан хууль, дүрэм, журам, стандарт тэдгээрийг мэргэжилтэнд танилцуулах, олон нийтэд сурталчлах, мэдээлэл өгөх ажлыг зохион байгуулах ажлын хүрээнд дараах ажлуудыг хийж гүйцэтгэсэн. Үүнд:<br>- Хэнтий аймгийн ГХБХБГ-ын мэргэжилтэн, сумдын Газрын даамлуудад Газрын үнэлгээ, төлбөр, татварын цахим систем, Газрын биржийн цахим системд хийж гүйцэтгэсэн нэмэлт хөгжүүлэлтийн талаар 2024 оны 03 дугаар сарын 14-ний өдөр танхимаар сургалт зохион байгуулсан.<br>- Өвөрхангай аймгийн ГХБХБГ-ын мэргэжилтэн, сумдын Газрын даамлуудад Газрын үнэлгээ, төлбөр, татварын цахим систем, Газрын биржийн цахим системд хийж гүйцэтгэсэн нэмэлт хөгжүүлэлтийн талаар 2024 оны 03 дугаар сарын 28-ны өдөр цахимаар сургалт зохион байгуулсан.<br>- 21 аймгийн Газрын кадастрын мэргэжилтнүүдэд 2024 оны 5 дугаар сарын 30-ны өдөр зохион байгуулсан сургалтад газрын үнэлгээ, төлбөр, татвар, газрын | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | биржийн чиглэлээр сургалт орсон.<br>- Газрын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.1.2 дахь заалт болон 33.5 дахь хэсэгт өөрчлөлт орсонтой холбогдуулан Монгол улсын Засгийн газраас хэрэгжүүлж буй Хот хөдөөгийн сэргэлтийн хүрээнд өрнүүлж байгаа малчдын "Шинэ хоршоо хөдөлгөөн"-ийг хэрэгжүүлэх багийн гишүүн бэлтгэх сургалтад малчдын хоршоонд төсөл сонгон шалгаруулалтаар газар олгох асуудлаар 14 удаагийн сургалт хийсэн. 2024 оны 06 дугаар сарын 06-07-ны өдрүүдэд Архангай, Завхан аймагт зохион байгуулагдсан Шинээр байгуулагдсан болон шинэчлэн зохион байгуулагдсан хоршоодыг чадавхжуулах, бойжуулах бүсийн уулзалт зөвлөгөөн төсөл сонгон шалгаруулалтаар газар олгох асуудлаар танилцуулга хийсэн.<br>- 2024 оны 09 дүгээр сарын 18-ны өдөр Нийслэлийн Газар зохион байгуулалтын албаны Газрын биржийн хэлтсийн мэргэжилтэн, албан хаагчдад Газрын биржийн цахим системийн шинэчилсэн хувилбарт хэрхэн ажиллах талаарх сургалт зохион байгуулж, тус системийн туршилтын ажлыг хийж гүйцэтгэсэн.<br>- Холбооны бүгд найрамдах Герман улсын ахмад мэргэжилтэн Томас Шенк Герман болон Монгол улсын газрын төлбөр, татвар, газрын биржийн өнөөгийн нөхцөл байдлын талаар харьцуулсан дүгнэлт танилцуулга сургалтыг 2024 оны 09 дүгээр сарын 19 өдөр 21 аймгийн ГХБХБГ болон Нийслэл, дүүргийн | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | Газар зохион байгуулалтын албаны асуудал хариуцсан мэргэжилтнүүдэд танхим болон цахим хэлбэрээр зохион байгуулсан.<br>- Газрын биржийн цахим системийн шинэчилсэн хувилбар болон Газрын үнэлгээ, төлбөр, татварын цахим системийн нэмэлт хөгжүүлэлтийн сургалтыг 21 аймгийн Газрын харилцаа барилга, хот байгуулалтын газрын холбогдох мэргэжилтнүүдэд 2024 оны 10 дугаар сарын 2-4-ний өдрүүдэд, Нийслэл, Дүүргийн Газар зохион байгуулалтын албаны холбогдох мэргэжилтнүүдэд 10 дугаар сарын 15-ны өдөр тус зохион байгуулсан. | |

## ХОЁР. ТӨРИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЧАНАР, ХҮРТЭЭМЖИЙГ САЙЖРУУЛАХ ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭ

| Д/д | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Төсөв | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Зорилтот түвшин | Хүрсэн түвшин буюу хэрэгжилт /хүрээгүй бол тайлбар/ | Гүйцэтгэл -ийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| **2.1.6** | **Газрын үнэлгээ, төлбөр, татвар, газрын биржтэй холбоотой үйл ажиллагааг удирдан зохион байгуулах, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгөх, хяналт тавих** | **Үйл ажиллагаа, ургалт төсөв** | **Нийслэл, 21 аймаг** | **Газрын үнэлгээ, төлбөр, татвар, газрын биржийн системийг нэвтрүүлсэн.** | **Газрын үнэлгээ, төлбөр, татвар, газрын биржтэй холбоотой үйл ажиллагаанд хяналт тавьж, мэргэжил арга зүйгээр хангаж ажилласан байна.** | | |
| 2.1.6.1 | Газрын биржийн цахим системд газрын нөөц сан байгуулж, бүртгэх боломжийг бүрдүүлэх, газар хөгжүүлэлттэй холбоотой цахим | Үйл ажиллагаа | Систем хөгжүүлсэн байдал | Газрын биржийн цахим систем хэрэглээнд нэвтэрсэн | **Эхний хагас жилд:**<br>Газрын биржийн цахим системд нэмэлт хөгжүүлэлт хийх ажлын даалгаврыг боловсруулж, батлуулан гүйцэтгэгч шалгаруулах үйл ажиллагааг хууль, журмын | Нийслэлийн Газар зохион байгуулалтын албанд нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалтаар Газрын биржийн цахим системийн тоног төхөөрөмж, газрын удирдлагын нэгдсэн цахим системийн программ хөгжүүлэлтийн ажилд Газрын | 100 |



41

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | системд хөгжүүлэлт хийх | | | | дагуу зохион байгуулсан байна.<br>**Жилийн эцэст:**<br>Батлагдсан ажлын даалгаврын дагуу гүйцэтгэгчийн үйл ажиллагаанд хяналт тавьж, ажлыг бүрэн хүлээн авсан байна. | биржийн цахим систем (www.mle.mn)-д суурилсан холбогдох нэмэлт хөгжүүлэлтийн ажлыг тус газраас тавьсан шаардлагын дагуу гүйцэтгүүлэх, хамтран ажиллах талаар чиглэлийг хүргүүлж, Газрын биржийн цахим системд газрын нөөц сан байгуулж, бүртгэх боломжийг бүрдүүлэх, газар хөгжүүлэлттэй холбоотой цахим системд хөгжүүлэлт хийхээр төлөвлөгөөнд тусгасан.<br>Тус хөгжүүлэлтийн ажлыг гүйцэтгэж буй "Смарт Дата" ХХК-тай хамтран Газрын биржийн цахим системийн шинэчилсэн хувилбарт нөөцөд авах газрыг бүртгэх, анализ хийх болон газар хөгжүүлэлттэй холбоотой цахим системийн хөгжүүлэлтийг хийж гүйцэтгэсэн (https://mle.smartdata.mn/les/reserve/land).<br>Хөгжүүлэлтийн ажлыг тус газрын даргын зөвлөлийн 2024 оны 10 дугаар сарын 25-ны өдрийн 22 дугаар хуралдаанаар хэлэлцүүлж, эцсийн байдлаар хүлээж авсан. | |
| 2.1.6.2 | Газрын биржийн цахим систем болон Газрын төлбөр, татварын цахим системийн сервер, баазын ачааллыг бууруулж, байнгын нөөцлөх үйл ажиллагааг сайжруулж ачаалал тэнцүүлэгч (load balance) -ийн ашиглахаар нэмэлт хөгжүүлэлт хийх | Үйл ажиллагаа | Систем хөгжүүлсэн байдал | Газрын биржийн цахим систем болон Газрын төлбөр, татварын цахим систем хэрэглээнд нэвтэрсэн | **Эхний хагас жилд:**<br>Газрын биржийн цахим систем болон Газрын төлбөр, татварын цахим системд нэмэлт хөгжүүлэлт хийх ажлын даалгаврыг боловсруулж, батлуулан гүйцэтгэгч шалгаруулах үйл ажиллагааг хууль, журмын дагуу зохион байгуулсан байна.<br>**Жилийн эцэст:**<br>Батлагдсан ажлын даалгаврын дагуу гүйцэтгэгчийн үйл ажиллагаанд хяналт тавьж, ажлыг бүрэн хүлээн авсан байна. | "Газрын төлбөр үнэлгээ болон Газрын төлбөр татварын цахим системийн хөгжүүлэлт хийх" болон "Газрын биржийн цахим системийн нэмэлт хөгжүүлэлт (газрын дуудлага худалдаа, төсөл сонгон шалгаруулалт зохион байгуулах үйл ажиллагааг боловсронгуй болгох)" ажлуудын ажлыг даалгаврыг боловсруулсан бөгөөд тус ажлын даалгаварт Газрын биржийн цахим систем болон Газрын төлбөр, татварын цахим системийн сервер, баазын ачааллыг бууруулж, байнгын нөөцлөх үйл ажиллагааг сайжруулж ачаалал тэнцүүлэгч (load balance)-ийн ашиглахаар нэмэлт хөгжүүлэлтийн ажлыг тусгаж, шаардлагатай төсөв санхүүгийн тооцоо судалгааг гаргасан. | 100 |



42

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | Тус ажлуудын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулсан бөгөөд шалгарсан байгууллагуудтай гэрээ байгуулан нэмэлт, хөгжүүлэлтийн ажлыг хийж гүйцэтгэсэн.<br>Хөгжүүлэлтийн ажлыг тус газрын даргын зөвлөлийн 2024 оны 10 дугаар сарын 25-ны өдрийн 22 дугаар хуралдаанаар хэлэлцүүлж, эцсийн байдлаар хүлээж авсан. | |
| 2.1.6.3 | Газрын биржийн цахим системээс дуудлага худалдаа, төсөл сонгон шалгаруулалтаар олгосон газрын газар эзэмших ашиглах эрхийн гэрчилгээг хэвлэх, гэрээ байгуулах боломжийг бүрдүүлэх | Үйл ажиллагаа | Систем хөгжүүлсэн байдал | Газрын биржийн цахим систем хэрэглээнд нэвтэрсэн | **Эхний хагас жилд:**<br>Газрын биржийн цахим системд нэмэлт хөгжүүлэлт хийх ажлын даалгаврыг боловсруулж, батлуулан гүйцэтгэгч шалгаруулах үйл ажиллагааг хууль, журмын дагуу зохион байгуулсан байна.<br>**Жилийн эцэст:**<br>Батлагдсан ажлын даалгаврын дагуу гүйцэтгэгчийн үйл ажиллагаанд хяналт тавьж, ажлыг бүрэн хүлээн авсан байна. | Газрын биржийн цахим системийн нэмэлт хөгжүүлэлт (газрын дуудлага худалдаа, төсөл сонгон шалгаруулалт зохион байгуулах үйл ажиллагааг боловсронгуй болгох) 2024 оны 01 дүгээр сарын 23-ны өдрийн АД/2024-05 дугаар ажлын даалгаврыг боловсруулж батлуулсан.<br>Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн ерөнхий газрын даргын 2024 оны А/25 дугаар тушаалаар зөвлөх үйлчилгээний гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах Үнэлгээний хороог байгуулж, тендерийн баримт бичгийг боловсруулан Төрийн худалдан авах ажиллагааны цахим системээр Газрын биржийн цахим системийн нэмэлт хөгжүүлэлт (газрын дуудлага худалдаа, төсөл сонгон шалгаруулалт зохион байгуулах үйл ажиллагааг боловсронгуй болгох) ГЗБГЗЗГ/20240203008 тендер шалгаруулалтыг зохион байгуулж тендерт шалгарсан "Эрхэт инноваци" ХХК-тай 2024/57 дугаар гэрээ байгуулан Газрын биржийн цахим системийн хөгжүүлэлтийн ажлыг хийж гүйцэтгэсэн.<br>Энэхүү ажлын хүрээнд Газрын биржийн цахим системийн шинэчилсэн хувилбар (https://mle.smartdata.mn/les/auction)-т дуудлага худалдаа, төсөл сонгон шалгаруулалтын ялагчтай байгуулах | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | гэрээг цахимаар байгуулж, Газрын кадастрын мэдээллийн санд дуудлага худалдаа, төсөл сонгон шалгаруулалтаар газар эзэмших, өмчлөх өргөдлийг автоматаар үүсгэж, өргөдлийн явцыг хянаж байхаар хөгжүүлсэн.<br>Мөн дуудлага худалдаа, төсөл сонгон шалгаруулалтын ялагч газар эзэмших, ашиглах эрхийн гэрчилгээ болон гэрээг хэвлэж авах боломжтой болсон.<br>Хөгжүүлэлтийн ажлыг тус газрын даргын зөвлөлийн 2024 оны 10 дугаар сарын 25-ны өдрийн 22 дугаар хуралдаанаар хэлэлцүүлж, эцсийн байдлаар хүлээж авсан бөгөөд 2025 оны 01 дүгээр сарын 01-ний өдөр улсын хэмжээнд хэрэглээнд нэвтрүүлэхээр шийдвэрлэсэн. | |
| 2.1.6.4 | Дуудлага худалдаа, төсөл сонгон шалгаруулалтаар олгох болон худалдах, түрээслэх газрын байршлыг замчлах, 360 болон виртуал хувилбараар харуулах боломжийг бүрдүүлэх | Үйл ажиллагаа | Систем хөгжүүлсэн байдал | Газрын биржийн цахим систем хэрэглээнд нэвтэрсэн | **Эхний хагас жилд:**<br>Газрын биржийн цахим системд нэмэлт хөгжүүлэлт хийх ажлын даалгаврыг боловсруулж, батлуулан гүйцэтгэгч шалгаруулах үйл ажиллагааг хууль, журмын дагуу зохион байгуулсан байна.<br>**Жилийн эцэст:**<br>Батлагдсан ажлын даалгаврын дагуу гүйцэтгэгчийн үйл ажиллагаанд хяналт тавьж, ажлыг бүрэн хүлээн авсан байна. | Газрын биржийн цахим системийн нэмэлт хөгжүүлэлт (газрын дуудлага худалдаа, төсөл сонгон шалгаруулалт зохион байгуулах үйл ажиллагааг боловсронгуй болгох) 2024 оны 01 дүгээр сарын 23-ны өдрийн АД/2024-05 дугаар ажлын даалгаварт дуудлага худалдаа, төсөл сонгон шалгаруулалтаар олгох болон худалдах, түрээслэх газрын байршлыг замчлах, 360 болон виртуал хувилбараар харуулах боломжийг бүрдүүлэх ажлыг тусгаж, шаардлагатай төсөв санхүүгийн тооцоо судалгааг гаргаж батлуулсан.<br>Уг ажлын гүйцэтгэгчийг Төрийн худалдан авах ажиллагааны цахим системээр шалгаруулж, шалгарсан аж ахуйн нэгжтэй гэрээ байгуулан Газрын биржийн цахим системийн хөгжүүлэлтийн ажлыг хийж гүйцэтгэсэн.<br>Тус хөгжүүлэлтээр Газрын биржийн цахим системд дуудлага худалдаа, | 100 |



44

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | төсөл сонгон шалгаруулалтаар олгох болон худалдах, түрээслэх газрын байршлыг замчлах, 360 болон виртуал хувилбараар харуулах боломжийг бүрдүүлсэн (https://birj.smartdata.mn/auction).<br>Хөгжүүлэлтийн ажлыг тус газрын даргын зөвлөлийн 2024 оны 10 дугаар сарын 25-ны өдрийн 22 дугаар хуралдаанаар хэлэлцүүлж, эцсийн байдлаар хүлээж авсан бөгөөд 2025 оны 01 дүгээр сарын 01-ний өдөр улсын хэмжээнд хэрэглээнд нэвтрүүлэхээр шийдвэрлэсэн. | |
| 2.1.6.5 | Батлагдсан уулын ажлын болон баяжуулах үйлдвэрийн үйл ажиллагааны төлөвлөгөөтэй уялдуулан төлбөрийн хувь хэмжээг тооцоолж, үйл ажиллагааг бүрэн цахимжуулж, боловсронгуй болгох | Үйл ажиллагаа | Систем хөгжүүлсэн байдал | Газрын төлбөр, татварын цахим систем хэрэглээнд нэвтэрсэн | **Эхний хагас жилд:**<br>Газрын төлбөр, татварын цахим системд нэмэлт хөгжүүлэлт хийх ажлын даалгаврыг боловсруулж, батлуулан гүйцэтгэгч шалгаруулах үйл ажиллагааг хууль, журмын дагуу зохион байгуулсан байна.<br>**Жилийн эцэст:**<br>Батлагдсан ажлын даалгаврын дагуу гүйцэтгэгчийн үйл ажиллагаанд хяналт тавьж, ажлыг бүрэн хүлээн авсан байна. | Ашигт малтмал, газрын тосны газрын даргын 2024 оны 01 дүгээр сарын 26-ны өдрийн А/12 дугаар тушаалаар Геологи, уул уурхайн мэдээллийн систем болон Уул уурхайн кадастрын системд нэмэлт хөгжүүлэлт хийх ашигт малтмалын тусгай зөвшөөрөл болон тайлан төлөвлөгөөний мэдээллийг Газрын нэгдмэл сангийн удирдлагын нэгдсэн цахим системд холбох ажлыг зохион байгуулах, төсөвт өртөг, ажлын даалгавар зэргийг боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийг байгуулсан.<br>Газрын төлбөр, үнэлгээ болон Газрын төлбөр татварын цахим системийн нэмэлт хөгжүүлэлт 2024 оны 01 дүгээр сарын 23-ны өдрийн А/2024-06 дугаар ажлын даалгаврыг боловсруулж батлуулсан.<br>Мөн Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн ерөнхий газрын даргын 2024 оны А/23 дугаар тушаалаар зөвлөх үйлчилгээний гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах Үнэлгээний хороог байгуулж, тендерийн баримт бичгийг боловсруулан Төрийн худалдан авах ажиллагааны цахим системээр "Газрын төлбөр үнэлгээ болон Газрын | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | төлбөр татварын цахим системийн хөгжүүлэлт" хийх ГЗБГЗЗГ/ 20240203007 тендер шалгаруулалтыг зохион байгуулж тендерт шалгарсан байгууллагатай 2024/82 дугаар гэрээ байгуулан Газрын төлбөр татварын цахим системийн хөгжүүлэлтийн ажлыг хийж гүйцэтгэсэн. Ашигт малтмал, газрын тосны газраас ирүүлсэн дараах https://cmcs.mrpam.gov.mn/CMCS/ArcGISServer/WMS.ashx WFS сервис: https://cmcs.mrpam.gov.mn/CMCS/ArcGISServer/WFS.ashx сервисийг ирүүлсэн бөгөөд мэдээллийн санд холбож ашигт малтмалын тусгай зөвшөөрөлтэй иргэн, хуулийн этгээдийн ашиглаж буй газарт Газрын төлбөр, татварын цахим системээс газрын төлбөрийн тооцоолол, ногдуулалт, нэхэмжлэхийг үүсгэх бүрэн боломжтой болсон. Хөгжүүлэлтийн ажлыг тус газрын даргын зөвлөлийн 2024 оны 10 дугаар сарын 25-ны өдрийн 22 дугаар хуралдаанаар хэлэлцүүлж, эцсийн байдлаар хүлээж авсан. | |
| 2.1.6.6 | УИХ-аас батлагдсан Улсын хилийн зурвас газрын хил заагийг Газрын төлбөр, татварын цахим системд оруулж, хилийн зурвас газарт газар ашиглаж буй иргэн, хуулийн этгээдийн газрын төлбөр тооцоолох, чөлөөлөх боломжийг бүрдүүлэх | Үйл ажиллагаа | Систем хөгжүүлсэн байдал | Газрын төлбөр, татварын цахим систем хэрэглээнд нэвтэрсэн | **Эхний хагас жилд:** Газрын төлбөр, татварын цахим системд нэмэлт хөгжүүлэлт хийх ажлын даалгаврыг боловсруулж, батлуулан гүйцэтгэгч шалгаруулах үйл ажиллагааг хууль, журмын дагуу зохион байгуулсан байна. **Жилийн эцэст:** Батлагдсан ажлын даалгаврын дагуу гүйцэтгэгчийн үйл ажиллагаанд хяналт тавьж, | Газрын төлбөр, үнэлгээ болон Газрын төлбөр татварын цахим системийн нэмэлт хөгжүүлэлт 2024 оны 01 дүгээр сарын 23-ны өдрийн А/2024-06 дугаар ажлын даалгаварт УИХ-аас батлагдсан Улсын хилийн зурвас газрын хил заагийг Газрын төлбөр, татварын цахим системд оруулж, хилийн зурвас газарт газар ашиглаж буй иргэн, хуулийн этгээдийн газрын төлбөр тооцоолох, чөлөөлөх боломжийг бүрдүүлэх ажлыг тусгаж, ажлыг даалгаврыг батлуулсан. Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн ерөнхий газрын даргын 2024 оны А/23 дугаар тушаалаар | 100 |



46

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | ажлыг бүрэн хүлээн авсан байна. | зөвлөх үйлчилгээний гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах Үнэлгээний хороог байгуулж, тендерийн баримт бичгийг боловсруулан Төрийн худалдан авах ажиллагааны цахим системээр "Газрын төлбөр үнэлгээ болон Газрын төлбөр татварын цахим системийн хөгжүүлэлт" хийх ГЗБГЗЗГ/202402030007 тендер шалгаруулалтыг зохион байгуулж тендерт шалгарсан байгууллагатай 2024/82 дугаар гэрээ байгуулан нэмэлт хөгжүүлэлтийн ажлыг хийж гүйцэтгэсэн.<br>Монгол Улсын Их Хурлын 2022 оны 12 дугаар сарын 22-ны өдрийн тогтоолоор "Улсын хилийн зурвас" газрыг улсын тусгай хэрэгцээнд авсан бөгөөд нэмэлт хөгжүүлэлтээр түүний хэмжээ, заагийн дагуу Газрын төлбөр, татварын цахим системд бүртгэж, баталгаажуулан хилийн зурвас газарт газар ашиглаж буй иргэн, хуулийн этгээдийн газрын төлбөрийг Газрын төлбөрийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4 дэх хэсэгт заасан хөнгөлөлт, чөлөөлөлтийг тооцох боломжийг бүрдүүлсэн.<br>Хөгжүүлэлтийн ажлыг тус газрын даргын зөвлөлийн 2024 оны 10 дугаар сарын 25-ны өдрийн 22 дугаар хуралдаанаар хэлэлцүүлж, эцсийн байдлаар хүлээж авсан. | |
| 2.1.6.7 | Нийт иргэн, хуулийн этгээдэд олгогдсон газрын дуудлага худалдааны анхны үнийг тухайн үед хүчин төгөлдөр мөрдөгдөж байсан тогтоол, аргачлалын дагуу тооцож, нэхэмжлэлийг үүсгэж, дуудлага худалдааны анхны үнэ | Үйл ажиллагаа | Систем хөгжүүлсэн байдал | Газрын үнэлгээний цахим системд хэрэглээнд нэвтэрсэн | **Эхний хагас жилд:**<br>Газрын үнэлгээний цахим системд нэмэлт хөгжүүлэлт хийх ажлын даалгаврыг боловсруулж, батлуулан гүйцэтгэгч шалгаруулах үйл ажиллагааг хууль, журмын дагуу зохион байгуулсан байна.<br>**Жилийн эцэст:** | Газрын төлбөр үнэлгээ болон Газрын төлбөр татварын цахим системийн хөгжүүлэлт хийх 2024 оны 01 дүгээр сарын 23-ны өдрийн АД/2024-06 дугаар ажлын даалгаврыг боловсруулж батлуулсан. Тус ажлын даалгаварт нийт иргэн, хуулийн этгээдэд олгогдсон газрын дуудлага худалдааны анхны үнийг тухайн үед хүчин төгөлдөр мөрдөгдөж байсан тогтоол, аргачлалын дагуу тооцож, | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | төлсөн эсэх лавлагааг гаргах хөгжүүлэлт хийх | | | | Батлагдсан ажлын даалгаврын дагуу гүйцэтгэгчийн үйл ажиллагаанд хяналт тавьж, ажлыг бүрэн хүлээн авсан байна. | нэхэмжлэлийг үүсгэж, дуудлага худалдааны анхны үнэ төлсөн эсэх лавлагааг гаргах хөгжүүлэлт хийх ажлыг нарийвчлан тусгаж, шаардлагатай төсөв, зардлын тооцоог гаргасан.<br>Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн ерөнхий газрын даргын 2024 оны А/23 дугаар тушаалаар зөвлөх үйлчилгээний гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах Үнэлгээний хороог байгуулж, тендерийн баримт бичгийг боловсруулан Төрийн худалдан авах ажиллагааны цахим системээр "Газрын төлбөр үнэлгээ болон Газрын төлбөр татварын цахим системийн хөгжүүлэлт хийх" (ГЗБГЗЗГ/202401030О7) тендер шалгаруулалтыг зохион байгуулж шалгарсан байгууллагатай 2024/82 дугаар гэрээ байгуулан хөгжүүлэлтийн ажлыг хийж гүйцэтгэсэн.<br>Мөн тус ажлын хүрээнд 2003 оноос 2018 он хүртэл хугацаанд батлагдсан 5 шийдвэр тус бүрийн дагуу нийслэл, 21 аймаг, 330 сумын газрын үнэлгээний бүс тогтоосон ИТХ-ын тогтоол болон үнэлгээний бүсийн зургийг тоон /*shp/ хэлбэрээр гаргуулах тухай 2024 оны 04 сарын 22-ны өдрийн 1/1045 тоот албан бичгийг 21 аймгийн ГХБХБГ болон Нийслэлийн газар зохион байгуулалтын албанд хүргүүлж, 21 аймаг, Нийслэлийн 9 дүүргийн ИТХ-ын тогтоолоор батлагдсан бүсийн зургийг *shp файл болгон засварлаж мэдээллийн санд оруулсан. Иргэн, хуулийн этгээдэд олгогдсон нийт газарт дуудлага худалдааны анхны үнийг эрх бүхий этгээдийн шийдвэр, тухайн үед хүчин төгөлдөр мөрдөгдөж байсан аргачлалыг үндэслэн тооцох модулийг хөгжүүлэх ажлын хүрээнд | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | дараах хөгжүүлэлтийг хийж гүйцэтгэсэн. Үүнд:<br>Одоо дуудлага худалдааны анхны үнийг тооцоолж байгаа хэсгийг 1 бүлэг үүсгэж оруулсан байх бөгөөд өмнө нь хүчин төгөлдөр мөрдөгдөж байсан дуудлага худалдааны анхны үнэ тооцох аргачлалуудад хамаарах газрын үнэлгээний бүс, зэрэглэл, суурь үнэлгээ болон итгэлцүүрийг нийт 4 бүлэг үүсгэж оруулсан.<br>Гэрээний бүртгэлийн дэлгэнгүй хэсэгт "Дуудлага худалдааны анхны үнэ" товчийг нэмж оруулсан бөгөөд энэ хэсэгт тухайн нэгж талбарын дуудлага худалдааны анхны үнийг хүчин төгөлдөр мөрдөгдөж байсан аргачлал тус бүрээр тооцоолж харуулдаг болсон.<br>Хөгжүүлэлтийн ажлыг тус газрын даргын зөвлөлийн 2024 оны 10 дугаар сарын 25-ны өдрийн 22 дугаар хуралдаанаар хэлэлцүүлж, эцсийн байдлаар хүлээж авсан. | |
| 2.1.6.8 | Газрын үнэлгээний цахим системээс газрын нөхөн олговрын болон суурь үнэлгээг тогтоож, хэрэглэгчдэд мэдээллээр үйлчлэх боломжийг бүрдүүлэх | Үйл ажиллагаа | Систем хөгжүүлсэн байдал | Газрын үнэлгээний цахим систем хэрэглээнд нэвтэрсэн | **Эхний хагас жилд:**<br>Газрын үнэлгээний цахим системд нэмэлт хөгжүүлэлт хийх ажлын даалгаврыг боловсруулж, батлуулан гүйцэтгэгч шалгаруулах үйл ажиллагааг хууль, журмын дагуу зохион байгуулсан байна.<br>**Жилийн эцэст:**<br>Батлагдсан ажлын даалгаврын дагуу гүйцэтгэгчийн үйл ажиллагаанд хяналт тавьж, ажлыг бүрэн хүлээн авсан байна. | Газрын төлбөр үнэлгээ болон Газрын төлбөр татварын цахим системийн хөгжүүлэлт хийх 2024 оны 01 дүгээр сарын 23-ны өдрийн АД/2024-06 дугаар ажлын даалгаварт Газрын үнэлгээний цахим системээс газрын нөхөн олговрын болон суурь үнэлгээг тогтоож, хэрэглэгчдэд мэдээллээр үйлчлэх боломжийг бүрдүүлэх ажлыг тусгаж батлуулсан. Шаардлагатай төсөв санхүүгийн тооцоо судалгааг гаргасан.<br>Уг ажлын тендер сонгон шалгаруулалтыг Төрийн худалдан авах ажиллагааны цахим системээр зохион байгуулсан бөгөөд шалгарсан байгууллагатай 2024/82 дугаар гэрээ байгуулан нэмэлт хөгжүүлэлтийн ажлыг хийсэн. Уг ажлын хүрээнд | 100 |



49

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | газрын үнэлгээний цахим системийн нөхөх олговор гэсэн цэсний нөлөөлөлд өртсөн газар гэсэн хэсэгт оруулж мэдээллийн сан үүсгэсэн. Дээрх мэдээллийн хүрээнд Дорнод аймаг 7 нэгж талбарт, Дорноговь аймаг 6 нэгж талбарт, Өвөрхангай аймаг 54 нэгж талбарт, Өмнөговь аймаг 13 нэгж талбарт, Ховд аймаг 8 нэгж талбарт, Нийслэлийн хэмжээнд 2022, 2023 онуудад 1030 нэгж талбарт нөхөх олговор олгож газар чөлөөлөлт хийсэн судалгааг ирүүлсэн. Уг мэдээллийн сан иргэн, хуулийн этгээдийн нэр, регистрийн дугаар, хаяг, байршил, талбайн хэмжээ, чөлөөлсөн талбай, газар чөлөөлсөн үндэслэл, газар чөлөөлсөн огноо, газрын зориулалт, нөхөх олговор олгосон хэлбэр, мөнгөн дүн, нөхөх олговор олгох тухай захирамжийн мэдээлэл зэргийг агуулсан.<br>Хөгжүүлэлтийн ажлыг тус газрын даргын зөвлөлийн 2024 оны 10 дугаар сарын 25-ны өдрийн 22 дугаар хуралдаанаар хэлэлцүүлж, эцсийн байдлаар хүлээж авсан. | |
| 2.1.6.9 | Газар, үл хөдлөх эд хөрөнгийн зах зээлийн үнийн мэдээнд үндэслэн газрын зах зээлийн үнийн бүсчлэлийг харуулах | Үйл ажиллагаа | Систем хөгжүүлсэн байдал | Газрын үнэлгээний цахим систем хэрэглээнд нэвтэрсэн | **Эхний хагас жилд:**<br>Газрын үнэлгээний цахим системд нэмэлт хөгжүүлэлт хийх ажлын даалгаврыг боловсруулж, батлуулан гүйцэтгэгч шалгаруулах үйл ажиллагааг хууль, журмын дагуу зохион байгуулсан байна.<br>**Жилийн эцэст:**<br>Батлагдсан ажлын даалгаврын дагуу гүйцэтгэгчийн үйл ажиллагаанд хяналт тавьж, ажлыг бүрэн хүлээн авсан байна. | Газрын төлбөр үнэлгээ болон Газрын төлбөр татварын цахим системийн хөгжүүлэлт хийх 2024 оны 01 дүгээр сарын 23-ны өдрийн АД/2024-06 дугаар ажлын даалгаварт Газар, үл хөдлөх эд хөрөнгийн зах зээлийн үнийн мэдээнд үндэслэн газрын зах зээлийн үнийн бүсчлэлийг харуулах ажлыг тусгаж батлуулсан. Шаардлагатай төсөв санхүүгийн тооцоо судалгааг гаргасан.<br>Уг ажлын тендер Төрийн худалдан авах ажиллагааны цахим системээр зохион байгуулагдаж, шалгарсан байгууллагатай 2024/82 дугаар гэрээ байгуулан цахим системийн нэмэлт, хөгжүүлэлтийн ажил хийсэн. Газрын | 100 |



50

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | зах зээлийн үнийн мэдээнд үндэслэн газрын үнэд нөлөөлөх хүчин зүйлсийн утгыг тооцоолон масс үнэлгээний аргаар үнэлж гаргасан 1м.кв газрын суурь үнэлгээнд тулгуурлан газрын үнэлгээний бүсчлэл тогтоох, зураглах хэсгийг газрын үнэлгээний цахим системийн үнэлгээний бүсчлэл гэсэн модульд хөгжүүлсэн бөгөөд систем автомаатаар үнэлгээний бүсийг зураглан харуулж, илүү нарийвчлалтай хуваах зурагладаг болсон. Хөгжүүлэлтийн ажлыг тус газрын даргын зөвлөлийн 2024 оны 10 дугаар сарын 25-ны өдрийн 22 дугаар хуралдаанаар хэлэлцүүлж, эцсийн байдлаар хүлээж авсан. | |
| 2.1.6.10 | Аймаг, нийслэлийн ИТХ-аар газрын төлбөрийн хувь, хэмжээ, итгэлцүүр, түүнийг хэрэглэх заа г хязгаарыг шинэчлэх бүрд Газрын төлбөр, татварын системд бүртгэж баталгаажуулан газрын төлбөрийг тооцоолох, ногдуулалтыг үүсгэх ажлыг зохион байгуулах | Үйл ажиллагаа | Тухай бүр | Газрын төлбөр, татварын системийг нэвтрүүлсэн. | **Эхний хагас жилд:** ИТХ-аар батлагдсан тогтоол, хувь хэмжээг системд баталгаажуулсан байна. | Булган аймгийн Газрын төлбөрийн хувь, хэмжээ, итгэлцүүр, түүнийг хэрэглэх заа г хязгаарыг ИТХ-аар батлуулж, 12/22 тоот тогтоол, Завхан аймгийн Газрын төлбөрийн хувь, хэмжээ, итгэлцүүр, түүнийг хэрэглэх заа г хязгаарыг ИТХ-аар батлуулж, 54/2022 тоот тогтоолыг сум тус бүрээр Газрын төлбөр, татварын цахим системд бүртгэж баталгаажуулж, бүсийн хил заа г, төлбөр тооцох итгэлцүүрийн утгуудыг системд оруулах ажлыг зохион байгуулж шинэчилсэн хувь хэмжээгээр газрын төлбөрийг тооцож, ногдуулалт үүсгэн Татварын системд илгээсэн.<br>Мөн Дорноговь аймгийн Замын-Үүд чөлөөлт бүсэд төлбөр тооцох хувь хэмжээг Газрын төлбөр, татварын цахим системд бүртгэж баталгаажуулж, бүсийн хил заа г, төлбөр тооцох итгэлцүүрийн утгуудыг системд оруулах ажлыг зохион байгуулж, шинэчилсэн хувь хэмжээгээр газрын төлбөрийг тооцож, ногдуулалт үүсгэн Татварын системд илгээсэн. | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | Харин нийслэл болон бусад аймаг, чөлөөлт бүс Газрын төлбөрийн хувь, хэмжээ, итгэлцүүр, түүнийг хэрэглэх зааг хязгаарыг шинэчлэн батлаагүй болно. | |
| 2.1.6.11 | Газрын кадастрын мэдээллийн санд бүртгэлтэй бүх нэгж талбарт төлбөр бодох, ногдуулалт хийж, нэхэмжлэх үүсгэх ажлыг зохион байгуулах, хяналт тавих | Үйл ажиллагаа | Нийт хүчинтэй гэрээний тоо | Газрын төлбөр, татварын системийг нэвтрүүлсэн. | **Эхний хагас жилд:** Хуульд заасан хугацаанд Татварын нэгдсэн системд бүх ногдуулалтыг илгээсэн байна. | Аймаг, нийслэлийн ИТХ-ын тогтоолоор шинэчлэн батлагдсан тогтоолын хувь хэмжээгээр газрын төлбөрийг тооцох боломжтой бүх нэгж талбарт газрын төлбөрийг бодуулж, 524,188 нэгж талбарт 161.4 тэрбум төгрөгийн ногдуулалт, 477,927 нэгж талбарт 155.8 тэрбум төгрөгийн нэхэмжлэх үүсгэсэн. Мөн аймаг, нийслэлээс Газрын кадастрын мэдээллийн санд бүртгэлтэй бүх нэгж талбарт төлбөр бодох, ногдуулалт хийж, нэхэмжлэх үүсгэх ажилд хяналт тавин ажилласан. | 100 |
| 2.1.6.12 | Газар, үл хөдлөх, эд хөрөнгийн албан татвар ногдуулах, нэхэмжлэх үүсгэх ажлыг зохион байгуулах, хяналт тавих | Үйл ажиллагаа | Өмчилсөн нийт нэгж талбар | Газрын төлбөр, татварын системийг нэвтрүүлсэн. | **Эхний хагас жилд:** Хуульд заасан хугацаанд Татварын нэгдсэн системд бүх ногдуулалтыг илгээсэн байна. | Улсын хэмжээнд газар, үл хөдлөх эд хөрөнгийн албан татварыг 304,851 нэгж талбарт 1.0 тэрбум төгрөгийн ногдуулалт, 205,045 нэгж талбарт 621.8 сая төгрөгийн нэхэмжлэхийг үүсгэж, Татварын системд илгээсэн.<br>21 аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын газрын үнэлгээ, төлбөр, татвар хариуцсан мэргэжилтний газар, үл хөдлөх, эд хөрөнгийн албан татвар ногдуулах, нэхэмжлэх үүсгэх ажилд хяналт тавьж зарим алдаатай үүссэн ногдуулалт, нэхэмжлэхийг засварлаж, мэргэжил, арга зүйн зөвлөгөөгөөр ханган ажилласан. | 100 |
| 2.1.6.13 | Үл хөдлөх эд хөрөнгө зуучлагч байгууллагаас газар, үл хөдлөх хөрөнгийн үнийн мэдээлэл, Газар, үл хөдлөх хөрөнгийн барьцааны болон нөхөн | Урсгал төсөв | 5000-8000 газар, үл хөдлөх хөрөнгийн зах зээлийн үнэ | Кадастрын мэдээллийн нэгдсэн системээр зохион байгуулах боломж бүрдсэн. | **Эхний хагас жилд:** Газрын биржийн цахим системд 1500-2500 газар, үл хөдлөх хөрөнгийн үнийн мэдээллийг цуглуулж, дүн шинжилгээ хийсэн байна.<br>**Жилийн эцэст:** | 2024 оны жилийн эцсийн байдлаар Газрын биржийн цахим системд нийт 104'155 газар, үл хөдлөх хөрөнгийн зах зээлийн үнийг бүртгэсэн бөгөөд үүнээс тухайн онд нийт 9,456 газар, үл хөдлөх хөрөнгийн зах зээлийн үнийн мэдээг нэмж бүртгэсэн. | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | олговрын үнийн мэдээлэл, зах зээлийн санал болгосон буюу зарлан мэдээлсэн үнийн мэдээллийг тус тус цуглуулах | | | | Газрын биржийн цахим системд 5000-8000 газар, үл хөдлөх хөрөнгийн үнийн мэдээллийг цуглуулж, дүн шинжилгээ хийсэн байна. | Тухайн онд нэмж бүртгэсэн газар, үл хөдлөх хөрөнгийн зах зээлийн үнийн мэдээнээс 9,388 худалдагдсан буюу газар, үл хөдлөх хөрөнгийн гэрээний, 68 үнэлэгдсэн, барьцаа болон нөхөн олговрын үнийн мэдээлэл тус тус ээлж байна. Нийт цуглуулсан үнийн мэдээг зориулалтаар ангилахад гэр бүлийн хэрэгцээний газар 7,890, худалдаа үйлчилгээний газар 555, үйлдвэрлэлийн газар 129, хөдөө аж ахуйн газрын 873 тус тус бүртгэсэн байна.<br>Мөн тухайн онд бүртгэсэн үнийн мэдээнээс үл хөдлөх хөрөнгөгүй 7,649, үл хөдлөх хөрөнгөтэй 1,807 газар, үл хөдлөх хөрөнгийн зах зээлийн үнийн мэдээ бүртгэгдсэн бөгөөд нийт 17,564.46 га газар эдийн засгийн эргэлтэд орсон байна. | |
| 2.1.6.14 | Зах зээлийн үнийн мэдээг газрын үнэлгээний системд оруулж дүн шинжилгээ хийх, масс үнэлгээ хийх | Үйл ажиллагаа | 5000-8000 газар, үл хөдлөх хөрөнгийн зах зээлийн үнэ | Газрын үнэлгээний системийг нэвтрүүлсэн. | **Эхний хагас жилд:**<br>Газрын биржийн цахим системд бүртгэгдсэн 1500-2500 газар, үл хөдлөх хөрөнгийн үнийн мэдээллийг үнэлгээний цахим системд оруулж дүн шинжилгээ хийсэн байна.<br>**Жилийн эцэст:**<br>Газрын биржийн цахим системд бүртгэгдсэн 5000-8000 газар, үл хөдлөх хөрөнгийн үнийн мэдээллийг үнэлгээний цахим системд оруулж дүн шинжилгээ хийсэн байна. | Газрын үнэлгээний цахим системд өссөн дүнгээр бүртгэгдсэн 39,795 нэгж талбарын зах зээлийн үнийн мэдээг ашиглан 2023 онд инженерийн болон хүрээлэн буй орчны, нийгмийн дэд бүтцийн 10182 үнэд нөлөөлөх хүчин зүйлсийн мэдээллийг оруулж, нийт 1,5228,870 нэгж талбарт газрын үнэлгээний цахим системээр масс үнэлгээ хийж дүн шинжилгээ хийсэн. | 100 |

## ГУРАВ. ХУУЛИАР ТУСГАЙЛАН ОЛГОСОН ЧИГ ҮҮРГИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭ

| Д/д | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа | Төсөв | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Зорилтот түвшин | Хүрсэн түвшин буюу хэрэгжилт /хүрээгүй бол тайлбар/ | Гүйцэтгэл -ийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|



53

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | | | | | | |
| **Стратеги төлөвлөгөөний зорилго 3.1 Улсын хэмжээнд газар зүйн нэрийн тодруулалт хийнэ.** | | | | | | | |
| **3.1.7** | **Газрын нэгдмэл сангийн тооллого, бүртгэл, газрын нэгдмэл санд гарч буй өөрчлөлт, шилжилт хөдөлгөөнийг бүртгэх, хянах** | **Үйл ажиллагаа** | **Газрын нэгдмэл сангийн 2022 оны улсын нэгдсэн тайлан** | **Газрын нэгдмэл сангийн 2021 оны улсын нэгдсэн тайлан Засгийн газарт танилцуулагдсан.** | **Газрын нэгдмэл сангийн тооллого, бүртгэлийн үйл ажиллагаар эрхэлж газрын нэгдмэл санд гарч буй өөрчлөлт, шилжилт хөдөлгөөн бүртгэгдсэн байна.** | | |
| 3.1.7.1 | Газрын нэгдмэл сангийн 2023 оны тайланг аймаг, нийслэлээс хүлээн авч нэгтгэх, улсын нэгдсэн тайланг гарган Засгийн газарт танилцуулах, Газрын нэгдмэл сангийн 2023 оны улсын нэгдсэн тайлангийн товхимлыг хэвлүүлэх, тайланг хэрэглэгчдэд хүргэх | Үйл ажиллагаа | Газрын нэгдмэл сангийн 2023 оны улсын нэгдсэн тайлан, товхимол | Газрын нэгдмэл сангийн 2022 оны улсын нэгдсэн тайлан хэвлэгдсэн. | **Эхний хагас жилд:** Газрын нэгдмэл сангийн 2023 оны улсын нэгдсэн тайлан Монгол Улсын Засгийн газрын хуралдаанд танилцуулагдсан байна. Газрын нэгдмэл сангийн 2023 оны улсын нэгдсэн тайлангийн товхимол хэвлэгдэн хэрэглэгчдийн хүртээл болсон байна. | Газрын даргын 2024 оны 01 дүгээр сарын 02-ны өдрийн А/01 тоот тушаалаар байгуулагдсан ажлын хэсэгт Газрын нэгдмэл сангийн 2023 оны улсын нэгдсэн тайланг нэгтгэн гаргах ажлын хэсэгт орж Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газар, нийслэлийн Газар зохион байгуулалтын албанаас хүлээн авч, нэгтгэн улсын хэмжээний тайлан гаргасан.<br>Уг ажлын хэсэг нь 21 аймаг, нийслэлийн газрын нэгдмэл сангийн 2024 оны тайланг хянаж шалган хүлээн авч нэгтгэн Улсын нэгдсэн тайланг гарган Газрын даргын дэргэдэх Зөвлөлийн 2023 оны 3 дугаар сарын 7-ны өдрийн хуралдаанд орж холбогдох тайлбар мэдээллийг өгч тус хурлаас гарах зөвлөмжид холбогдох саналыг өгсөн. | 100 |
| **3.1.12** | **Газрын зөрчил, маргаантай холбоотой** асуудлыг шийдвэрлэх, **холбогдох арга хэмжээг зохион байгуулах** | **Үйл ажиллагаа** | **Шийдвэрлэсэн албан бичиг,** өргөдлийн тоо | **2023 онд иргэний болон захиргааны шүүх, Авлигатай тэмцэх газар, эрх бүхий байгууллагаас ирүүлсэн 387 албан бичиг, иргэний 60** | **Шүүх, Авлигатай тэмцэх газар болон эрх бүхий** байгууллагаас **шинжээчээр томилсон тогтоол, захирамжийн хэрэгжилтийг хангах, дүгнэлт гаргах, нотлох баримтыг хүргүүлсэн байна.** | | |



54

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | **өргөдлийг шийдвэрлэсэн.** | | | |
| 3.1.12.1 | Шүүх, Авлигатай тэмцэх газар болон эрх бүхий байгууллагаас шинжээчээр томилсон тогтоол, захирамжийн хэрэгжилтийг хангах, дүгнэлт гаргаж хүргүүлэх ажлыг зохион байгуулах | Үйл ажиллагаа | Шийдвэрлэсэн албан бичиг, өргөдлийн тоо, тушаалын биелэлт | 2023 онд 39 ажлын хэсэг байгуулж, 53 шинжээчийн дүгнэлтийг хүргүүлсэн. | Шүүх, Авлигатай тэмцэх газар болон эрх бүхий байгууллагаас шинжээчээр томилсон тогтоол, захирамжийн хэрэгжилтийг хангаж ажлын хэсэг байгуулах тухай газрын даргын тушаал гарсан байна.<br>Газрын даргын тушаалаар болон бусад байгууллагатай зөвшилцөн байгуулагдсан ажлын хэсэгт ажиллана.<br>Шинжээчийн дүгнэлтийг хүргүүлсэн байна. | Дараах Шүүх, Авлигатай тэмцэх газар болон эрх бүхий байгууллагаас шинжээчээр томилсон тогтоол, захирамжийн хэрэгжилтийг хангах, дүгнэлт гаргаж хүргүүлэх ажлыг зохион байгуулан ажиллаж байна. Үүнд:<br>- Авлигатай тэмцэх газрын мөрдөн шалгах хэлтсийн М.Тэмүүжин мөрдөгч, комиссарын 2024 оны 03 дугаар сарын 07-ны өдрийн тогтоолоор эрүүгийн хэргийн 240200064 дугаартай хэрэгт шинжээчийн дүгнэлт гаргах бүхий ажлын хэсэг;<br>- Авлигатай тэмцэх газрын мөрдөн шалгах хэлтсийн Б.Цолмон мөрдөгч, комиссарын 2024 оны 03 дугаар сарын 26-ны өдрийн тогтоолоор эрүүгийн хэргийн 240200018 дугаартай хэрэгт шинжээчийн дүгнэлт гаргах бүхий ажлын хэсэг;<br>- Авлигатай тэмцэх газрын мөрдөн шалгах хэлтсийн мөрдөгч, комиссар Г.Гантулгын 2024 оны 02 дугаар сарын 20-ны өдрийн тогтоолоор эрүүгийн хэргийн 2302000210033 дугаартай хэрэгт шинжээчийн дүгнэлт гаргах бүхий ажлын хэсэг;<br>- Авлигатай тэмцэх газрын мөрдөн шалгах хэлтсийн Б.Батбилэг албаны дарга, ахлах комиссарын 2023 оны 10 дугаар сарын 25-ны өдрийн тогтоолоор эрүүгийн хэргийн 230200520 дугаартай хэрэгт Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газрын 2023 оны 10 дугаар сарын 10-ны өдрийн А/165 дугаар тушаалаар байгуулагдсан ажлын хэсэгт; | 100 |



55

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | - Авлигатай тэмцэх газрын мөрдөн шалгах хэлтсийн мөрдөгч, Г.Амгаланбаатар комиссарын 2024 оны 05 дугаар сарын 03-ны өдрийн тогтоолоор эрүүгийн хэргийн 232800252 дугаартай хэрэгт шинжээчийн дүгнэлт гаргах бүхий ажлын хэсэг;<br>- Авлигатай тэмцэх газрын мөрдөн шалгах хэлтсийн мөрдөгч, Б.Ариунсайхан комиссарын 2024 оны 05 дугаар сарын 31-ний өдрийн тогтоолоор эрүүгийн хэргийн 230200283 дугаартай хэрэгт шинжээчийн дүгнэлт гаргах бүхий ажлын хэсэг;<br>- Авлигатай тэмцэх газрын мөрдөн шалгах хэлтсийн мөрдөгч, Г.Гантулга комисарын 2024 оны 08 дугаар сарын 22-ны өдрийн тогтоолоор эрүүгийн хэргийн 2302004750026 дугаартай хэрэгт шинжээчийн дүгнэлт гаргах бүхий ажлын хэсэг:<br>- Авлигатай тэмцэх газрын мөрдөн шалгах хэлтсийн М.Батсайхан мөрдөгч, комиссарын 2024 оны 02 дугаар сарын 07-ны өдрийн тогтоолоор эрүүгийн хэргийн 230200363 дугаартай хэрэгт | |

## ДӨРӨВ. ХУУЛИАР ОЛГОСОН НИЙТЛЭГ ЧИГ ҮҮРГИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭ

| Д/д | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Төсөв | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Зорилтот түвшин | Хүрсэн түвшин буюу хэрэгжилт /хүрээгүй бол тайлбар/ | Гүйцэтгэл -ийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| 4.1.1 | Удирдлагаас болон хурлаас өгөгдсөн үүрэг даалгаврыг хэрэгжүүлэх, тайлагнах | Үйл ажиллагаа | Үүрэг даалгаврын тоо | Жил бүр хийгддэг. | Өгөгдсөн үүрэг даалгаврыг хэрэгжүүлж, тухай бүр тайлагнасан байна. | 2024 оны гуравдугаар улирлын байдлаар удирдлага болон хурлаас нийт 5 үүрэг даалгавар өгснийг гүйцэтгэж, "Эйбл" Байгууллагын дотоод удирдлагын цогц систем биелэлтийг дэлгэрэнгүй бичиж оруулсан байна. | 100 |



56

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 4.1.2 | Ажлын хэсгийн бүрэлдэхүүнд ажиллаж, тайланг тушаалд заасан хугацаанд холбогдох мэргэжилтэнд хүргүүлэх | Үйл ажиллагаа | Тушаалд заасан хугацаа | Жил бүр хийгддэг. | Ажлын хэсэгт ажиллаж, хэрэгжилтийг тухай бүр тайлагнасан байна. | Дараах ажлын хэсгийн бүрэлдэхүүнд орж ажиллан, заасан хугацаанд холбогдох үүрэг даалгаврыг биелүүлж, тайлагнаж байна. Үүнд:<br>- Газрын нэгдмэл сангийн 2023 оны улсын нэгдсэн тайланг нэгтгэн гаргах ажлын хэсгийг Газрын даргын 2024 оны 01 дүгээр сарын 02-ны өдрийн А/01 тоот тушаалаар ажлын хэсэгт;<br>- Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2023 оны Засгийн газрын чиглэлийн хүрээнд "Монгол Улсын газрын нэгдмэл сан, газар эзэмшил, ашиглалтын бүртгэл, түүний хяналтын үйл ажиллагааг шалгаж, холбогдох арга хэмжээг хуулийн хүрээнд авч хэрэгжүүлэх ажил"-ын дагуу тус Газрын даргын 2024 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн А/17 дугаар тушаалаар байгуулагдсан иргэн, хуулийн этгээдэд газар өмчлүүлсэн, эзэмшүүлсэн, ашиглуулсан асуудлыг шалгаж, цаашид авах арга хэмжээний санал боловсруулж, танилцуулах үүрэг бүхий ажлын хэсэгт;<br>- Газрын даргын 2024 оны 03 дугаар сарын 14-ний өдрийн А/71 дугаар тушаалаар Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн ерөнхий газрын дэргэдэх Соёл, спорт, эрүүл мэндийн зөвлөлийн ажлын хэсэгт;<br>- Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн ерөнхий газрын даргын 2024 оны А/23 дугаар тушаалаар байгуулагдсан "Газрын төлбөр үнэлгээ болон Газрын төлбөр татварын цахим системийн хөгжүүлэлт хийх" зөвлөх үйлчилгээний гүйцэтгэгчийг сонгон | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | шалгаруулах Үнэлгээний хороонд;<br>- Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн ерөнхий газрын даргын 2024 оны А/25 дугаар тушаалаар байгуулагдсан "Газрын биржийн цахим системийн нэмэлт хөгжүүлэлт (газрын дуудлага худалдаа, төсөл сонгон шалгаруулалт зохион байгуулах үйл ажиллагааг боловсронгуй болгох)" зөвлөх үйлчилгээний гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах Үнэлгээний хороонд;<br>- Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2023 оны Засгийн газрын чиглэлийн хүрээнд "Монгол Улсын газрын нэгдмэл сан, газар эзэмшил, ашиглалтын бүртгэл, түүний хяналтын үйл ажиллагааг шалгаж, холбогдох арга хэмжээг хуулийн хүрээнд авч хэрэгжүүлэх ажил"-ын дагуу тус Газрын даргын 2024 оны 09 дүгээр сарын 03-ны өдрийн А/253 дугаар тушаалаар байгуулагдсан 2003-2023 онуудад иргэн, хуулийн этгээдэд газар өмчлүүлсэн, эзэмшүүлсэн, ашиглуулсан асуудлыг шалгаж, цаашид авах арга хэмжээний санал боловсруулж, танилцуулах үүрэг бүхий ажлын хэсэгт;<br>- Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн ерөнхий газрын даргын 2024 оны А/200 дугаар тушаалаар батлагдсан "Шинэ хоршоо хөдөлгөөн"-ий хүрээнд шинээр байгуулагдсан болон шинэчлэн зохион байгуулагдсан хоршоодыг чадавхжуулах, бойжуулах бүсийн уулзалт зөвлөгөөн;<br>- Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн ерөнхий | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | газрын даргын 2024 оны А/235 дугаар тушаалаар байгуулагдсан Монгол Улсад Газрын харилцааны мэргэжлийн байгууллага үүсэж хөгжсөний 70 жилийн ойг тэмдэглэн өнгөрүүлэх ажлыг зохион байгуулах дэд ажлын хэсэгт.<br>- Монгол улсын Сангийн сайдын 2024 оны 09 дүгээр сарын 02-ны өдрийн 151 дүгээр тушаалаар батлагдсан Хөрөнгийн үнэлгээний тухай хууль шинэчилсэн найруулга/-ийн 7 дугаар зүйлийн 7.2.10 дахь заалтад заасан үнэлгээний журам, аргачлалын төслийг боловсруулах, хэлэлцүүлэх үүрэг бүхий ажлын хэсэгт;<br>- Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн ерөнхий газрын даргын 2024 оны А/287 дугаар тушаалаар байгуулагдсан Монгол Улсын Засгийн газрын 2018 оны 182 дугаар тогтоолоор баталсан газрын суурь үнэлгээг шинэчлэн боловсруулах үүрэг бүхий ажлын хэсэгт; | |
| 4.1.3 | Тогтоол шийдвэрийн биелэлт гаргах | Үйл ажиллагаа | Тогтоол, шийдвэрийн тоо | Жил бүр хийгддэг. | Холбогдох тогтоол шийдвэрийн биелэлтийг цаг хугацаанд нь тайлагнасан байна. | Дараах тогтоол шийдвэрийн биелэлт цаг тухай бүрт нь гаргаж байна. Үүнд:<br>- Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 110 дугаар тогтоолын хэрэгжилтэд хяналт, шалгалт хийх, дүгнэлт гаргах үүрэг бүхий Засгийн газрын 107 дугаар тушаалаар байгуулагдсан ажлын хэсгээс гаргасан хуваарийн дагуу төрийн байгууллагуудаар явж үйл ажиллагаандаа хэрэглэж байгаа цахим систем болон газрын нэгдмэл сангийн удирдлагын нэгдсэн цахим системд холбогдох боломжтой байдлын талаар дүгнэлт гаргаж ажлын хэсэгт хүргүүлсэн. | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | - Засгийн газрын хэрэг эрхлэх газраас ирүүлсэн хэг/265 дугаар албан бичгийн дагуу 2024 оны 04 сарын 19-ний өдрийн А/128 дугаар тушаалаар хамтарсан ажлын хэсэг байгуулж, ажлын үр дүнг Хот, хөдөөгийн сэргэлт, газар зохион байгуулалтын үндэсний хороонд хүргүүлсэн.<br>- Газрын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.1.2 дахь заалт болон Монгол улсын Засгийн газрын 2024 оны 187 дугаар тогтоолоор "Газар эзэмшүүлэх, ашиглуулах төсөл сонгон шалгаруулах журам"-д нэмэлт өөрчлөлт орсонтой холбогдуулан малчдын хоршоонд төсөл сонгон шалгаруулалтаар газар олгож буй асуудлаар 7 хоног бүр биелэлт гаргаж танилцуулж байна. | |
| 4.1.4 | Хугацаатай албан бичиг, өргөдөл гомдол шийдвэрлэх, хяналт тавьж ажиллах | Үйл ажиллагаа | Шийдвэрлэсэн албан бичиг, өргөдөл, гомдлын тоо | Жил бүр хийгддэг. | Нэгжид ирсэн хугацаатай албан бичиг, өргөдөл гомдлыг заасан хугацаанд нь шийдвэрлэсэн байна. | 2024 оны жилийн эцсийн байдлаар тус хэлтэст нийт 165 албан бичиг хуваарилагдан ирснээс хариутай 70, хариугүй 95 албан бичиг байна. Хариутай 70 бичгийн 70-ийг нь шийдвэрлэсэн.<br>Мөн иргэн, аж ахуйн нэгж байгууллагаас нийт 38 өргөдөл, хүсэлт ирсний 38-г нь шийдвэрлэсэн.<br>Мөн тус хэлтсээс 73 албан бичгийг боловсруулан иргэн, аж ахуйн нэгж, байгууллагуудад хүргүүлсэн байна. | 100 |
| 4.1.5 | Хөтлөх хэргийн нэрийн жагсаалтын дагуу архивын баримт бүрдүүлэх, хавтаслах, байгууллагын архивт хүлээлгэн өгөх | Үйл ажиллагаа | Архивт хүлээлгэн өгсөн баримтын тоо | Жил бүр хийгддэг. | Нэгжийн урьд онд хийсэн ажлын баримт бичгийг тайлант оны эхний улиралд багтаан байгууллагын архивт хүлээлгэн өгөх ажлыг зохион байгуулсан байна. | Тус ажлын хүрээнд 2023 онд ирүүлсэн албан бичиг, өргөдөл, гомдлын цаасан хувийг хүлээлгэн өгсөн.<br>Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн ерөнхий газрын даргын 2024 оны А/23 дугаар тушаалаар байгуулагдсан "Газрын төлбөр үнэлгээ болон Газрын төлбөр татварын цахим системийн хөгжүүлэлт хийх", 2024 оны А/25 дугаар тушаалаар байгуулагдсан "Газрын биржийн цахим системийн | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | нэмэлт хөгжүүлэлт (газрын дуудлага худалдаа, төсөл сонгон шалгаруулалт зохион байгуулах үйл ажиллагааг боловсронгуй болгох)" зөвлөх үйлчилгээний гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тендерийн баримт, бичгийг байгууллагын архивт хүлээлгэн өгөхөөр ажиллаж байна. | |

## ТАВ. МЭДЛЭГ ЧАДВАРАА ДЭЭШЛҮҮЛЭХ ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭ

| Д/д | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Төсөв | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Зорилтот түвшин | Хүрсэн түвшин буюу хэрэгжилт /хүрээгүй бол тайлбар/ | Гүйцэтгэл -ийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| 4.1.1 | Программ хангамжийн хөгжүүлэлтийн талаар бие даан суралцах | Үйл ажиллагаа | 1 сургалт | Бирж, Үнэлгээ, төлбөр татварын систем | Бирж, Үнэлгээ, төлбөр татварын системийн бүтэц, зохион байгуулалт, өгөгдлийн дэд бүтэц, програмчлалын хэлийг мэдэж авсан байна | Газрын бирж, үнэлгээ, төлбөр татварын системийн системийн бүтэц, зохион байгуулалт, өгөгдлийн сан, програмчлалын хэлний талаар бие даан судалж Газрын үнэлгээ, төлбөр татварын цахим системийн хөгжүүлэлт хийх, Газрын биржийн цахим системийн нэмэлт хөгжүүлэлт (газрын дуудлага худалдаа, төсөл сонгон шалгаруулалт зохион байгуулах үйл ажиллагааг боловсронгуй болгох) ажлын гүйцэтгэгч "Эрхэт Инноваци" ХХК-ний нэмэлт хөгжүүлэлтийн ажлын явцад хамтран оролцож, программ хангамжийн хөгжүүлэлтийн талаар суралцаж байна. | 100 |

ТАЙЛАН ГАРГАСАН:

ГАЗРЫН БИРЖИЙН ХЭЛТСИЙН ДАРГА ______ Ш.МАНДАХЗУЛ

__oOo__



61